БАТЛАВ:
БОАЖЯ-НЫ Хүрээлэн буй орчин, байгалийн
нөөцийн удирдлагын газрын дарга /А.ЭНХБАТ/

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:
“Цагаан дэлгэрэх өргөө” ХХК-ийн Гүйцэтгэх захирал /Г.МӨНХЗУЛ/

# ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ЦАГААН ДЭЛГЭРЭХ ӨРГӨӨ” ХХК-ИЙН АЖИЛЧДЫН ХОТХОН, АВТО ЗОГСООЛ БАЙГУУЛАХ ТӨСЛИЙН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/Аж ахуйн нэгжийн регистрийн дугаар: 3641856/



Хянасан:
Өмнөговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын
газрын мэргэжилтэн /Б.Оргилмаа/

Тайлан бичсэн:
Цагаан дэлгэрэх өргөө ХХК-ийн
ХАБЭА-БО мэргэжилтэн /Л.Энхцэцэг/

2022 он

Улаанбаатар хот

# 1. БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Манай компани нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын 1-р баг буюу Номгон багийн нутаг дэвсгэрт "Ажилчдын хотхон, авто зогсоол байгуулах" төслийг 2020 оноос хойш хэрэгжүүлэн ажиллаж байна. Төслийн хүрээнд Цагаан хаданд үйл ажиллагаа явуулж байгаа тээврийн компаниудын ажилтнуудыг амрах байр, хоол хүнсээр хангаж чанартай үйлчилгээ үзүүлэх, тав тухтай байдлыг бий болгох бизнесийн үндсэн төлөвлөгөөний дагуу ажиллаж байна.

"Цагаан Дэлгэрэх Өргөө" ХХК-ийн захиалгаар "Ханзаа Сервис" ХХК нь хоногт 60 $м^3$ ахуйн гаралтай бохир ус хүлээн авч биологийн аргаар цэвэрлэж, цэвэрлэгдсэн бохир усыг ууршуулах талбайд нийлүүлэх хүчин чадал бүхий цэвэрлэх байгууламж байгуулан, барилга байгууламж ашиглалтанд орсны дараа бүрэн хүчин чадлаар ажиллаж сар тутам шинжилгээ хийлгэн ажиллахаар төлөвлөж байна.

2022 оны 10-р сард "Оргил турбин инженеринг" ХХК-аар ажилчдын хотхоны халаалтанд зориулагдсан "ЭХУХЗ" /ШГ/ маркын 1000 кВт, 600кВт-ын усан халаалтын зуухыг суурилуулан хүлээн авч ашиглалтанд оруулла.

2022 оны 10 сард B, C блок бүхий 3 давхар, A блок бүхий 2 давхар 1031 хүний өрөө бүр дотроо ариун цэврийн өрөөтэй ажилчдын хотхоныг ашиглалтад оруулан Улсын комисст хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна.

"Цагаан Дэлгэрэх Өргөө" ХХК 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ доорхи асуудалд голлон анхаарч ажиллалаа. Үүнд:

1. Хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох
2. Бохир ус цэвэрлэх байгууламжийг туршилтын горимоор ашиглаж эхлүүлэх
3. Хөрсний элэгдэл, доройтлыг бууруулах, орчны тохижилт мод бут тарих ажлыг зохион байгуулах

1.1 Хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох ажлын хүрээнд;

- 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр Өмнөговь аймгийн Ханбогд сумын Засаг даргатай байгуулсан "Хог хаягдлын үйл ажиллагаа эрхлэх гэрээ"-ний дагуу багийн нэгдсэн хогийн цэгт хогийг төвлөрүүлэн хаяж байгаа.
- Хатуу хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, "Ханбогд вейст менежмент центр" ХХК-тай 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр байгуулсан "Эмнэлгийн аюултай болон эрсдэлтэй хог хаягдлыг тээвэрлэх, Халдваргүйжүүлэх, устгах, аюулгүй болгох гэрээ"-ний дагуу халдваргүйжүүлэн устгаж байна.
- Хөрсийг элэгдэл, бохирдлоос урьдчилан сэргийлж, ШУА-ийн Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн Хөрсний лабораторит хөрсний механик найрлага, бүтцийн шинжилгээ, "SGS IMME" ХХК-ийн лабораторит хөрсний бүтэц дэх хүнд металлын найрлага, бохирдлын хэмжээг тодорхойлох шинжилгээ хийлгэн ажиллаж байна.
- "Ханбогд хот тохижилт" ОНӨААТҮГ газартай "Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг хураах тээвэрлэх гэрээ" байгуулсан боловч Шуурхай штабын хөл хорио, дэглэмийн хамтран ажиллах гэрээг 12 сард гэрээг ахийн байгуулахаар байна.
- Кемпийн хогийн цэгийг энгийн, нойтон, дахин ашиглах гэж ангилан, тасалгаануудаар тусгаарлаж, хаягжуулан ашиглаж байна.
- Хогийн цэгт 7 хоног бүр байнгын халдваргүйжүүлэлт хийж, хөрс, агаар бохирдох эрсдэлээс хамгаалж байна.

1.2 Бохир ус цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагааг эхлүүлэх ажлын хүрээнд;

- Ханбогд сумын Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн А/24 тоот "Хаягдал ус зайлуулах цэг тогтоох тухай" захирамжид заасан цэгт бохир ус цэвэрлэх байгууламжийг байгуулах ажлыг эхлүүлсэн.

- Ахуйн гаралтай бохир усыг биологийн аргаар цэвэрлэх байгууламжийг “Хаанзаа” ХХК хийж гүйцэтгэж байна.
- Цэвэрлэх байгууламжаас гарах саарал ус болон лагийг улирал болгон итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлж, цаашид кемпийн мод, бут, зүлэгжүүлэлтэнд ашиглахаас гадна зам талбайн усалгаанд ашиглах, 2923 онд хэрэгжих Нарны сэргээгдэх эрчим хүчний ногоон байгууламжийн усалгаанд ашиглахаар төлөвлөгөөтэй ажиллаж байна.

1.3 Хөрсний элэгдэл, доройтлыг бууруулах, орчны тохижилт мод бут тарих ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд:

- Гаалийн хяналтын бүсийн талбайгаас Оюу толгойн хатуу хучилттай зам хүртэлх 2.3 км урттай, 30 см зузаантай, 6 м өргөнтэй 1 үе бүхий сайжруулсан замыг “Хөвсгөл сүлд” ХХК-аар гүйцэтгүүлэн ашиглаж хөрсний элэгдэл эвдрэлээс хамгаалсан.
- Эдэлбэр газрын хөрсний бүтэц, механик бүрэлдэхүүнийг ШУА-ийн Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн Хөрсний лабораторит шинжлүүлэн хөрсний үржил шимийн ерөнхий түвшинг тогтоосон.
- Хөрсний бүтэц, байгаль цаг уурын онцлогт тохиромжтой сайн ургадаг сухай, бүйлс, улиасын 80 гаруй суулгацыг суулгаж, арчилгаа тордолгоо хийж ургуулсан.

## 2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| № | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ | Хугацаа | Зардал | Үр дүн |
|---|---|---|---|---|---|
| Агаарын чанар | | | | | |
| 1 | Уурын зууханд утааны шүүлтүүр суурилуулах | Уурын зуух 2022.11 сард шинээр ашиглалтанд орсон | 2023 оноос хэрэгжинэ. | Дотоод төлөвлөлт | Агаарын чанарт сөрөг нөлөө үүсгээгүй. |
| 2 | Уурын зуухны шүүлтүүрийг тогтмол цэвэрлэх, ба солих | | | | |
| *Хөрсөн бүрхэвч (газрын гадарга)* | | | | | |
| 1 | Барилга байгууламжийн ажил бүрэн дууссаны дараагаар элэгдэлд өртсөн газруудыг шимт хөрсөөр хучиж, ногоон байгууламж бий болгох | Барилга байгууламж бүрэн дуусаагүй төлөвлөлтийн дагуу явагдаж байгаа бөгөөд ногоон байгууламжийн суурийг тавьж мод тарьж эхлүүлсэн. | 2022.05-09 сар | 0.2 сая | Амрах байр орчим мод тарьснаар орчны агаарыг цэвэршүүлж амрах аятай нөхцлийг бүрдүүлсэн. |
| 2 | Ажилчдын хотхоны хүний хөл хөдөлгөөн их байх газруудад хайргаар явган хүний зам засах | Амрах байр, ажлын байр болон үйлчлэх хэсгүүдийн хооронд хайргаар явган хүний зам засч ашигладаг | Тухай бүрд авч хэрэгжүүлсэн. | Дотоод төлөвлөлтөөр хийгдсэн. | Хөрсний эвдрэл гэмтлээс хамгаалсан. |
| 3 | Хог хаягдлыг зориулалтын саванд хадгалж, сумын нэгдсэн хогийн цэгт зөөвөрлөн хаяж байх, ариутгал халдваргүйтгэлийг тогтмол хийх | Хатуу хог хаягдлыг зориулалтын хогийн саванд цуглуулан, “Хүслэн хийморь” ХХК болон байгууллагын ариутгагч ариутгал халдваргүйтгэлийг тогтмол хийж хэвшсэн. | “Хүслэн хийморь” ХХК улиралд 1 удаа, дотоод ариутгал 7 хоног тутам | 1.8 сая | Хогийн цэгт ариутгал, халдваргүйтгэл тогтмол хийж хөрсийг бохирдлоос хамгаалсан. |
| *Усны нөөц* | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1 | Ус ашиглах гэрээг холбогдох байгууллагуудтай байгуулах | Ус ашиглах гэрээг Ханбогд сумын Засаг даргатай 2022.08.30-ны өдөр байгуулсан 2022/04 тоот гэрээ байгуулан ажиллаж байна. /Хавсралт-1/ | Үйл ажиллагааны туршид | 1 сая | Унд ахуйн усны MNS 0900:2018 стандартын шаардлага хангасан усыг хэрэглэснээр уснаас шалтгаалах халдвартай болон халдваргүй өвчнөөс урьдчилан сэргийлж байна. |
| 2 | Ус хэрэглэх үед хяналтгүй их урсгаж хэрэглэх | Усны хэрэглээг багасгах зорилгоор халуун ус, ариун цэврийн өрөөнд “Усаа хэмнэе” санамж, зөвлөмж байрлуулан байнгын хяналт тавьж, үргүй зардал гаргахаас урьдчилан сэргийлж ажиллаж байна. | Тогтмол | Үйл ажиллагааны зардлаар хийгдсэн | |
| 3 | Төслийн үйл ажиллагаанд ашиглах худгийн усны чанарт шинжилгээ хийж, үр дүнгээс нь шалтгаалан усны онцлогт тохирсон ундны усыг зөөлрүүлэх эсвэл цэнгэгжүүлэх төхөөрөмжийг суурилуулж ашиглах | Төслийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа унд ахуйн усыг ШУА-ын Газарзүй Геоэкологийн хүрээлэн, МХЕГ-ын ХАБҮЛЛ-т химийн, нян судлалын шинжилгээ хийлгэн, эрүүл ахуй, стандартын шаардлага хангасан усыг хэрэглэж байна.. /Хавсралт-2/ | Хагас жилд тутам | Үйл ажиллагааны зардлаар хийгдсэн. | |
| *Ургамалан нөмрөг* | | | | | |
| 1 | Барилга угсралтын ажил явагдаагүй талбайд үлдсэн орон нутгийн ургамлыг хамгаалах,нөхөн тарилт хийх<br>Барилгын үйл ажиллагаа дууссаны дараа элэгдэлд орсон талбайг өнгөн хөрсөөр бүрхэж, ургамалжуулах | Барилга угсралтын ажил үргэлжлэн явагдаж байгаа ба ашиглагдаж байгаа талбайд говийн байгал, хөрсөнд ургах тохиромжтой 3 төрлийн 80 гаруй мод бут тарьж ургуулсан. | 2022.04-2022.09 | Үйл ажиллагааны зардлаар хийгдсэн. | MNS 5918:2008 “Байгаль орчин. Эвдэрсэн газрыг ургамалжуулах.<br>Техникийн ерөнхий шаардлага” стандартыг ханган ажиллаж байна. |
| 2 | Машин техникийн шатахуун, тос тосолгоо, гидравлик шингэний асгаралт, шүүрэлтийн хяналтыг тогтмол хийх | Машин техникийн шатахуун, тос тосолгоо, гидравлик шингэний асгаралт, шүүрэлтэд тогтмол хяналт хийх, хөрсний бохирдол үүсгээгүй. | Тогтмол | | |
| *Амьтны аймаг* | | | | | |
| 1 | Төслийн талбай түүний ойр орчимд хог хаягдлыг ил задгай цуглуулснаас мал амьтад тэжээл хайж ирэх орогнох, хордож болзошгүй | Хатуу хог хаягдлыг зориулалтын саванд цуглуулан, ариутгал халдваргүйтгэл тогтмол хийж, мал амьтан хорхой шавьж орогнохгүй, үржихгүй | 7 хоногт 2-3 удаа | Үйл ажиллагааны зардлаар хийгдсэн | Өөрийн эзэмшлийн үйл ажиллагаа явуулж байгаа талбайг бүрэн хашаажуулан, мал амьтан |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | байх нөхцлийг бүрдүүлсэн. | | | орохоос сэргийлэн 2х4 метрийн хашаа хийсэн. |
| Сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний нийт зардал 1.0 сая төгрөг | | | | | |

## 3. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

"Цагаан дэлгэрэх өргөө" ХХК нь "Ажилчдын хотхон, авто зогсоол" төслийн барилга байгууламжийг үе шаттай хэрэгжүүлэх ба 2021-2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд "Ногоон байгууламж"-ийг барилга байгууламжийн ажил дууссаны дараа хэрэгжүүлэхээр заасан байгаа тул Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн ажлыг 2022 оноос хийж эхлүүлээд байна.

Кемпийн орчинд амрах байрыг тойруулан 2022.05 сард говийн хөрс, байгал цаг уурын онцлогт тохиромжтой сайн ургадаг сухай, бүйлс, улиасын 80 гаруй суулгацыг суулгаж, усалгаа тордолгоо тогтмол хийж ногоон байгууламжийн эхлэлийг тавьсан.





Мод тарих явц



Усалгаа



Моджуулсан байдал

## 4. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

"Цагаан дэлгэрэх өргөө" ХХК-ийн "Ажилчдын хотхон, авто зогсоол" төслийн үйл ажиллагаа явуулж байгаа талбай болон түүний орчмын нутагт нь түүх соёлын өв, дурсгалд тооцож болохуйц газар, археологийн болон палеонтологийн олдвор одоогоор тохиолдоогүй.

Цаашид үйл ажиллагааны явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрсэн үед “Монгол Улсын Үндсэн хууль”-ийн I бүлгийн 7 дугаар зүйлд “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна” гэж заасны дагуу түүх, соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалж хамгаалах, сурталчлах, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулахтай холбоотой үүрэг хариуцлагаа мөрдөж ажиллах нь зүйтэй” гэсэн үүрэг хүлээн ажиллаж байна.

## 5. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| № | Хог хаягдлыг бууруулах арга хэмжээ | Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ | Хугацаа | Зардал | Үр дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | Хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгаж, ялгах зориулалтын тэмдэг тэмдэглэгээтэй, цоорч гэмтээгүй, салхиар хог тархахааргүй тагтай, шингэн нэвчихгүй, угааж цэвэрлэхэд хялбар, галд тэсвэртэй материалаар хийгдэж салхины доод талд байршуулсан хогийн саванд хаях | Ажилчдын ажлын болон амрах байрууд, үйлчилгээний цэгүүдэд зориулалтын хогийн тагтай савнууд байрлуулан хогийг ангилж, салхины ноёлох чигийн дор байрлуулсан кемпийн нэгдсэн хогийн цэгт цуглуулж хаядаг. | Тогтмол | Дотоод төлөвлөл-төөр хийгдсэн. | Хогийг ангилан ялгаж цуглуулснаар хогийн хэмжээ багасаж, орчны бохирдлыг бууруулж, эрүүл орчныг бүрдүүлсэн. |
| 2 | Ажилчдын хотхоны хогийн нэгдсэн цэгт тогтмол ариутгал,цэвэрлэгээ хийх | Кемпийн нэгдсэн хогийн цэг болон хог цуглуулах савнуудад “Хүслэн хийморь ХХК”-тай байгуулсан гэрээний дагуу улирал тутам, байгууллагын ариутгагч байнгын халдваргүйтгэл хийж хэвшсэн. /Хавсралт-3,4/ | Байнгын ариутгал 7 хоног тутам | 1,200,000 | Хогийн цэгт хорхой шавьж цуглах тэдгээр амьтдаар халдварт өвчин дамжих нөхцлийг бууруулсан. |
| 3 | Ажилчдын хотхоны хогны савуудыг хог хаягдлын уутаархангаж, хог ил задгай хаяхгүй байх, ил задгай бие засахгүй байх санамж, зааварчилгааг тогтмол өгөх | Амрах байр болон ажлын байрны хогийн савыг хогийн уутаар хангаж, ил задгай хог хаях асуудлыг зогсоосон ба кемпийн байрлагч хэсгийн холболттой ариун цэврийн өрөөгөөр бүрэн хангагдсан бөгөөд шаардлагатай үед 6 суудал бүхий энгийн бие засах газрыг ашигладаг. | Тогтмол | Дотоод төлөвлөл-төөр хийгдсэн. | Байрлагч нарыг ая тухтай эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлсэн. |
| 4 | ААНБ нь батлагдсан маягт болон “эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт”-ын дагуу хог хаягдлын тоо бүртгэлээ тухай бүр хөтөлж, журмаар тогтоосон хугацаанд тайлангаа сумын Засаг даргад хүргүүлэх | Энгийн хог хаягдлыг Ханбогд сумын Засаг даргатай, аюултай хог хаягдлыг “Ханбогд вейст менежмент центр” ХХК-тай 2022.11.07 өдөр байгуулсан гэрээний дагуу бүртгэл хөтөлж хаядаг. /Хавсралт-5.6/ | Төслийн үйл ажил-лагааны туршид | Дотоод төлөвлөл-төөр хийгдсэн. | Кемпээс гарах хог хаягдлыг тооцож, төлөвлөлт хийх, зардлыг тооцох боломжтой болсон. |
| 5 | Амрагчид, ажиллагсдын хэрэглээнээс гарах хог хаягдлыг нэгдсэн хогийн цэгт төвлөрүүлэн, тусгай зөвшөөрөл бүхий байгууллагатай гэрээ хийж | Хог хаягдлыг Ханбогд сумын Засаг даргатай 2022.01.06-ны өдөр байгуулсан “Хог хаягдлын үйл ажиллагаа | Тогтмол | Дотоод төлөвлөл-төөр хийгдсэн. | Хог хаягдлыг нэгдсэн нэг цэгт төвлөрүүлж хаяснаар |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Ханбогд сумын нэгдсэн хогийн цэгт төвлөрүүлэх | эрхлэх гэрээ”-ний дагуу багийн нэгдсэн хогийн цэгт төвлөрүүлж асгадаг. | | | орчны бохирдлыг эрс багасгасан. |
| 6 | Авто машин, машин механизмуудад хэрэглэсэн тос тосолгооны сав, цэвэрлэгээний бодис, эд анги дугуй зэрэг хог хаягдал гарсан тохиолдолд тэдгээрийг хаялгүйгээр хадгалж бүртгэл хөтлөх. Зориулалтын аргаар мэргэжлийн байгууллагын зөвлөмжийг үндэслэл болгон тээвэрлүүлэх буюу бусад шаардлагатай арга хэмжээг авах | Манай ажилчдын хотхон нь үйлчилгээний пикап машин болон бохир ус соруулж зөөдөг бохир зөөврийн машинтай, хүнд машин механизм ашигладаггүй учир тос тосолгооны сав, цэвэрлэгээний бодис, эд анги дугуй зэрэг хог хаягдал гардаггүй. | Тогтмол | Дотоод төлөвлөл-төөр хийгдсэн. | Тос тосолгооны сав, цэвэрлэгээний бодис машин механизмын эд анги зэрэг хог хаягдлаар орчны бохирдол үүсгэдэггүй. |
| Хог хаягдлын сөрөг нөлөөлөл болон түүний хэмжээг бууруулахад 1,825,000.00 төгрөг зарцуулсан. | | | | | |




Хогийн савны байршил, энгийн болон аюултай хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгадаг.



Кемпийн хогийн цэг



Хогийн цэгийн халдваргүйтгэл






Аюултай хог хаягдал цуглуулах сав　　　　　　　　Хогийн савнуудад хогийн уут хийж хэвшсэн

Хог хаягдлыг зөөвөрлөх явцад салхинд хийсч орчны бохирдол үүсэхээс сэргийлж хог зөөвөрлөх машины тэвш болон чиргүүлд хамгаалалтын өндөрлөгөө хийсэн.





Хог ачих, буулгах явц

## 6. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Ханбогд сумын нутагт үйл ажиллагаа явуулж буй “Цагаан дэлгэрэх өргөө” ХХК-ийн “Ажилчдын хотхон, авто зогсоол байгуулах” төсөл БОМ-н төлөвлөгөөний орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд 2022 онд унд болон ахуйн усны шинжилгээ 2 удаа авч ШУА-ын Газарзүй Геоэкологийн хүрээлэн, МХЕГ-ын ХАБҮЛЛ-т шинжлүүлж байнгын хяналт тавин ажиллаж байна.

| № | Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд | Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ | Хугацаа | Зардал | Үр дүн |
|---|---|---|---|---|---|
| | | *Агаарын орчин* | | | |
| 1 | Агаар бохирдуулагч нарийн болон том ширхэглэгт тоосонцор (Нийт тоос, PM10, PM2.5) | Уурын зуух ашиглалтанд ороогүй учраас энэ шинжилгээ хийгдээгүй. | Жилд 1 удаа | | Ажилчдын амрах, ажиллах орчинд агаарын бохирдол үүсгэх нөлөөлөлгүй болно. |
| 2 | Агаар бохирдуулагч хий $NO_2$,$SO_2$; | | Жилд 1 удаа | | |
| | | *Усан орчин* | | | |
| 1 | Ундны усанд Физик хими, нянгийн бүрэн шинжилгээ, Хүнд металлын шинжилгээ, | Унд болон ахуйн усыг ШУА-ын Газарзүй Геоэкологийн хүрээлэн, МХЕГ-ын ХАБҮЛЛ-т хими, нян судлал, хүнд | Жилд 2 удаа | 0.184 сая | MNS 0900:2018 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага стандартын шаардлага хангасан |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | металлын шинжилгээ хийлгэсэн. /Хавсралт-7/ | | | усаар хангагдсан. |
| 2 | Цэвэршүүлэх байгууламжийн уршуулах талбайн усанд Хаягдал усны ерөнхий шаардлага стандартад заасан үзүүлэлтүүд | Цэвэрлэх байгууламжийг “Хаанзаа” ХХК хариуцан ажилладаг. /Хавсралт-8/ | Жилд 1 удаа | 0.2 сая | |
| *Хөрсөн бүрхэвч* | | | | | |
| 1 | Ялзмаг, урвалын орчин (pH),давсжилт, карбонат ($CaCO_3$), хөдөлгөөнт кали ($K_2O$), хөдөлгөөнт фосфор ($P_2O_5$), Шингээгдсэн сууриуд Ca, Mg | Тухайн жил өнгөн хөрс хуулалт хийгдэж барилгын бүтээн байгуулалтын ажил хийгдэж, хөрсний шинжилгээг ШУА-ын Газарзүй Геоэкологийн хүрээлэнд хийлгэсэн /Хавсралт-9/ | Жилд 1 удаа | 0.2 сая | MNS 3297:2019 “Байгальхамгаалал. Хөрс. Хот суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх”, MNS 4920:2000 “Хөрсний чанар, хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ” стандартуудын хэрэгжилт хангагдана. |
| 2 | Механик бүрэлдэхүүн, чулуу,чийг, амь чийг, эзлэхүүн жин | Механик бүрэлдэхүүн, бүтцийн шинжилгээг ШУА-ын Газарзүй Геоэкологийн хүрээлэнд 2022.09.29-нд хийлгэсэн /Хавсралт-10/ | Жилд 1 удаа | 0.2 сая | |
| 3 | Хар тугалга (Pb), кадмий (Cd), хром (Cr), цайр (Zn), никель (Ni), Мөнгөн ус (Hg), Хүнцэл (As), | Хөрсний бүтэц дэх хүнд металлын найрлагыг “SGS IMME” ХХК-д шинжлүүлсэн. /Хавсралт-11/ | Жилд 1 удаа | 0.2 сая | |
| *Ургамлын аймаг* | | | | | |
| 1 | Ургамлын бүрхэц, биомасс, зүйлийн арви тодорхойлох | Ургамлын бүрхэц, хөрсний үржил шимийн ерөнхий түвшин бага гэж үнэлэгдсэн. | Жилд 1 удаа | 0.2 сая | Ургамлын хэвийн бүрхэц хадгалах төлөвлөх боломжтой болно. |
| Орчны хяналт шинжилгээ хийхэд 3,484,000.00 төгрөг зарцуулагдсан. | | | | | |

## 7. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Цагаан дэлгэрэх өргөө” ХХК-ийн “Ажилчдын хотхон, авто зогсоол байгуулах” төсөл нь дотоод аюулгүй ажиллагаандаа OHSAS 18001 буюу ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны журмыг нэвтрүүлэн ажиллаж, аваар ослогүй ажилласан.

| № | Болзошгүй аюул, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ | Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ | Хугацаа | Зардал | Үр дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | Аянга цахилгаан | Аянга цахилгааны газардуулгыг 2 цэгт хийсэн. | Төсөл үргэлж лэх явцад | Үйл ажиллагааны зардалд тусгаж зарцуулсан | Байгалийн гамшиг болон давагдашгүй хүчин зүйл тохиолдоогүй, гэнэтийн аваар осол гараагүй 365 хоног ажилласан. |
| 2 | Газар хөдлөлт | Гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг аймгийн Онцгой байдлын газраар батлуулан хэрэгжүүлж байгаа. | | | |
| 3 | Шороон шуурга | | | | |
| 4 | Аадар бороо | | | | |
| 5 | Үер | | | | |
| 6 | Халдварт өвчин | Ажилтнууд цар тахлын онцгой нөхцөл байдалд шаардлагатай хувцас хэрэглэлийг бүрэн өмсөж хэвшсэн, малгай, маск, нэг удаагийн | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хувцас хэрэглэл 500-1000, ариутгалын бодис 10-100 кг.г нөөцлөн ажиллаж байна. | | | |
| 7 | Шатах тослох материал | Шатах тослох материалыг шаардлагатай хэмжээнд ХАБ-ын ажилтны хяналтанд хэрэглэдэг. | | | |
| 8 | Хөдөлмөр хамгааллын дүрэм алдагдаж, ажиллагсад хамгаалах хэрэгслэл бүрэн ашиглаагүйгээс ажилчдын эрүүл мэнд нөлөөнд өртөх | Ажлын байрны зааварчилгаануудыг тогтмол өгч ажлын хувцас хамгаалах хэрэгслийг бүрэн өмсүүлж хэвшүүлсэн. | | | |



Цахилгааны газардуулга






Галын самбар　　　　　　　　　　　　Галын сарай





Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх халдваргүйтгэл

## 8. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

| № | Төлөвлөсөн арга хэмжээ | Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ | Хугацаа | Зардал | Үр дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам боловсруулж мөрдөх | Компанийн захирлын 2022.02.16-ны өдрийн А/04 тоот тушаалаар батлагдсан дотоод журмын 9.12 “Эрүүл мэнд, эрүүл ахуй” зүйлд байгаль орчинд ээлтэй байх ажилчдын заавал биелүүлэх, дагаж мөрдөх үүрэг хариуцлага, авах арга хэмжээг тодорхой зааж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллаж ирсэн. | Үйл ажиллагааны зардалд тусгаж шийдвэрлэсэн | Төслийн нийт хугацаанд | Амьдарч байгаа орчиндоо хог хаяхгүй байх, ил задгай бие засах, нус цэр хаяхгүй ёс журамтай байснаар хөрсний бохирдлыг бууруулах нөхцлийг бүрдүүлэн ажилласан. |
| 2 | Байгаль орчныг хамгаалах, хог хаягдлын талаар мэдлэг олгох, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул, мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай | Байгал орчныг хамгаалах, хог хаягдлын асуудлаар багийн байгал орчны байцаагчийн зохион байгуулсан сургалтанд 1 удаа, үйлдвэрлэлийн осол, гал түймрээс урьдчилан | | | Байгал орчныг хамгаалах, хог хаягдлыг ангилан ялгаж хогийн хэмжээг бууруулах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаарх сургалтыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран жилд 1 удаа зохион байгуулах | сэргийлэх, шаардлагатай үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний асуудлаар нийт 50 гаруй ажилтныг хамруулан ХАБ ажилтан сургалт зохион байгуулсан | | | гарсан тохиолдолд шуурхай арга хэмжээ авах, урьдчилан сэргийлэх мэдлэг эзэмшсэн. |
| 3 | Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангах | Манай компани нийт 80 ажилтантай бөгөөд халуун хүйтний улиралд өмсөх иж бүрэн ажлын хувцсаар хангаж, өмсгөж хэвшүүлсэн. | | | Халуун, хүйтэн болон ажлын онцгой нөхцөлд хэвийн ажиллах боломж бүрдүүлж, аюулгүй байдал хангагдана. |
| 4 | Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт жил бүр тогтмол хамруулах. Ажлын онцлогоос хамааруулан хувь хүний хамгаалалтын хэрэгслээр тогтмол хангах, хордлого тайлах хүнс, бэлдмэлээр хангаж байх | Ажилчдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх шинжилгээг Сүхбаатар дүүргийн ЭМТ-д хагас жилд 1 удаа, эрүүл мэндийн үзлэг шинжилгээг ХЭМСТ-д жилд 1 удаа байгуулсан гэрээний дагуу хамруулж, хөдөлмөрийн нөхцлөөс шалтгаалан хамгаалах хэрэгсэл, хордлого тайлах бэлдмэлээр тогтмол ханган ажиллаж байна. | Үйл ажиллагааны зардалд тусгаж шийдвэрлэсэн | Төслийн нийт хугацаанд | Ажилнуудын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх боловсруулах боломжтой болно. |
| 5 | Галын аюулаас хамгаалах хэрэгсэл,эрүүл ахуйн хэрэгслээр хангах | Ажилчдын амрах болон ажлын байрууд, үйлчилгээний хэсгүүдэд галын самбар, галын сарайг байрлуулан, анхны мэдэгдэхүүн олгох сургалтыг зохион байгуулж ажилласан. | Үйл ажиллагааны зардалд тусгаж шийдвэрлэсэн | Төслийн нийт хугацаанд | Галын аюулаас хамгаалах, шаардлагатай тохиолдолд шуурхай арга хэмжээ авах мэдэгдэхүүнтэй болсон. |
| 6 | Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОАЖЯ-нд хүргэн өгч байх | Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг цаг хугацаанд гаргаж өгсөн. | | | |
| 7 | Байгаль хамгаалахад орон нутгийн иргэдийн оролцоог идэвхжүүлэхсургалт, аян, уулзалт зөвлөгөөг жил бүр зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОМТ-г хэрэгжүүлэх ажилд тусгах | Ханбогд сумын Байгал орчны байцаагчийн зохион байгуулсан сургалтанд оролцож, хандив өгсөн. Мөн нутгийн малчин Хоролсүрэн гуайн хувийн бизнесийг дэмжин усны машин түрээслэн хамтран ажиллаж байна. | Үйл ажиллагааны зардалд тусгаж шийдвэрлэсэн | Төслийн нийт хугацаанд | |
| 8 | Төслийн эдэлбэр газарт Газрын төлөв байдлын хянан баталгааг хийлгэж, цаашид 5 жил тутамд мэргэжлийн байгууллагаар хийлгэх | Төслийн эдэлбэр газарт Газрын төлөв байдлын хянан баталгааг хийлгэсэн, хүчинтэй хугацаандаа байгаа болно. | | | |

**9. ДҮГНЭЛТ**

1. “Цагаан дэлгэрэх өргөө” ХХК Өмнөговь аймгийн Ханбогд сумын Номгон багийн нутагт “Ажилчдын хотхон, авто зогсоол” байгуулах төслийг хэрэгжүүлэхдээ “2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-г бүрэн хангаж ажилласан.

2. Төсөл хэрэгжүүлэх явцад байгал орчин, хүрээлэн байгаа орчны агаар, ус, хөрсийг хамгаалах асуудлаар харьяа сум, багийн удирдлагуудтай нягт хамтран ажиллаж, үүсч болох эрсдлийг бууруулахад гол анхаарлаа хандуулан үр дүнтэй ажилласан.

3. Төслийн хүрээнд хог хаягдлын хэмжээг багасгах, дахин ашиглах, боловсруулах боломжтой хогийг дахивар хүлээн авах газруудад тушаах ажлыг эхлүүлэн цаашид өргөжүүлэх тал дээр анхааран ажилласанбайна.

4. Компанийн ажилтнууд болон нийт байрлагч нарт хогийг ил задгай хаяхгүй байх, эх үүсвэр дээр нь ангилан ялгах арга техникийг зурагт хуудас, зөвлөмж болон цахим хэлбэрээр хүргэж, хэрэгжилтэнд нь хяналт тавьж ажилласнаар орчны бохирдлыг бууруулахад чухал нөлөө үзүүлсэн.

5. Ажилтнуудад ил задгай бие засах, нус цэр, шүлсээ хаяхыг цээрлэх, ёс зүйн хэм хэмжээг баримтлан ажиллаж амьдрахыг сурталчлан, зөрчил гаргасан ажилтнуудад байгууллагын дотоод журамд заасны дагуу арга хэмжээ тооцож ажиллласан нь хөрсний бохирдлыг бууруулах үр дүнтэй ажил болсон.

6. Унд ахуйн усыг зохистой, хэмнэлттэй ашиглах асуудлаар нээлттэй цорго бүрийн дэргэд “Ус чандмань эрдэнэ”, “Усаа хэмнье” зэрэг анхааруулга санамжийг байрлуулан, унд ахуйн усыг зохистой хэрэглэж сургаад тодорхой хэмжээнд хэмнэлт гарч байна.

Хавсралт 1

БАТЛАВ
ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД
СУМЫН ЗАСАГ ДАРГА

Х.НЭХИЙТ

2022 оны ... дугаар сарын ...

КИА0001 9051007

ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:
ЦАГААН ДЭЛГЭРЭХ ӨРГӨӨ ХХК-
ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Г.МӨНХЗУЛ

2022 оны 08 дугаар сарын 30

# УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2022 оны 08 дугаар сарын 30-ны өдөр Дугаар 2022/04 Их булаг

## Нэг. Ерөнхий нөхцөл

Энэхүү Ус ашиглах гэрээ /цаашид "Гэрээ" гэх/-г Усны тухай хуулийн 28.4, 28.6, 28.7, 29.1-д заасны дагуу аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас гаргасан 2022 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 22/018 дугаартай ус ашиглуулах дүгнэлт, Ханбогд сумын Засаг даргын олгосон 2022 оны 08 сарын 24-ны өдрийн А/299 тоот ус ашиглах зөвшөөрлийг тус тус үндэслэн:

Нэг талаас Ус ашиглуулагч / цаашид "Ус ашиглуулагч " гэх /-ийг төлөөлж Ханбогд сумын ЗДТГ-ын Уул уурхай-Ус хариуцсан Байгаль хамгаалагч Онолбаатар овогтой Ангараг,

Нөгөө талаас Ус ашиглагч /цаашид "Ус ашиглагч" гэх /-ийг төлөөлж Өмнөговь, Цогтцэций сум, 3-р баг, Цагаан-Овоо, 2-р өргөлтийн насосны зүүн тал "Ажилчдын хотхон" орших "Цагаан дэлгэрэх өргөө" ХХК (УБД: 1111016251, РД:3641856) Гүйцэтгэх захирал Г.Мөнхзул нар нь ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 1 жилийн хугацаатайгаар байгуулав.

## Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1 Ус ашиглах зориулалт:

-Унд, ахуй болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглана.

2.2 Ашиглах усны хэмжээ:

2.2.1 Унд-ахуй: 34.5 $м^3$/хон

2.2.2

2.2.3 үйлчилгээ $м^3$/хоног

2.2.4 эмчилгээ, сувилгаа, хүн/хоног

2.2.5 Нийт ашиглах усны хэмжээ: **11,385 м3/жил**

2.3. Усны чанар найрлага: Унд ахуйн уснаас дээж авч, улирал тутам шинжилгээ хийлгэн хариу болон дүгнэлтийг БОАЖГазарт хүргүүлэх

2.4 Усны эх үүсвэрийн

| | |
|---|---|
| Байршил | Ханбогд сумын Жавхлант баг, өөрийн эзэмшлийн |

| | |
|---|---|
| Солбицол | 1 худаг 42° 45.953'N, 107° 22.948'E |
| Барилга байгууламж | Цэвэр усны нөөцийн барилга, усны нөөцийн сав |
| Тоног төхөөрөмжийн нэр, марк | Ус өргүүр, ус гаралтын турба хоолой, Усны насосны удирдлага, Цахилгаан удирдлагын самбар |
| Хүчин чадал | |

2.5 Хаягдал усны: Унд ахуйн хэрэгцээнд ашигласан уснаас гарах хаягдал усны хэмжээ, чанар, найрлага, бохирдуулагч бодисын хэмжээ зэрэгт улирал тутам шинжилгээ хийлгэн хариу болон дүгнэлтийг БОАЖГазар-т ирүүлэх

Хаях цэгийн байршил: Хаягдал ус зайлуулах цэгийн Ханбогд сумын Засаг даргын 2021 оны 03 сарын 11-ны А/74 тоот захирамжаар 4098 м$^2$ талбайг олгосон байна.

Солбицол: 4725250, 704074

2.6 Хаягдал усын дахь бохирдуулах бодисын хэмжээ. Усны биохимийн шинжилгээний дүнг хавсаргана.

- Жинлэгдэх бодис, кг ........................................
- Органик бодис, кг ............................................
- Эрдэс бодис, кг ..............................................
- Хүнд металл, кг ..............................................
- Аюултай бохирдуулах бодис, гр

2.7 Бохир ус цэвэрлэх барилга байгууламжийн байршил, хүчин чадал, технологи, цэвэрлэх арга, цэвэрлэгээний түвшин:

2.8 Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох, бохирдохоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ:

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хугацаа | Зардал мян.төг | Хариуцагч |
|---|---|---|---|---|
| 1 | "Дэлхийн усны өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлэх | 2023.03.22 | - | ЗДТГ, Цагаан дэлгэрэх өргөө ХХК |
| 2 | Зэрлэг ан амьтдад зориулж уст цэг байгуулах ажилд оролцож дэмжлэг үзүүлэх | 2023.01 | - | ЗДТГ, Цагаан дэлгэрэх өргөө ХХК |

2.9 Усны тоолуурын:

Төрөл, нэр, дугаар: 202200226 , лацны дугаар 017

Загвар: LXSG-32

Тоолуурын тоо: Стандартчилал, хэмжил зүйн газраар баталгаажсан 1 тоолууртай.

Суурилуулсан байгууллага огноо:

Баталгаажуулсан байгууллага огноо: 2022.08.26

Тоолуурын заалт: 0

2.10 Ус ашигласны нэгж төлбөрийн хэмжээ:

Усны экологи эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах тухай Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 302 тогтоолоор Галба-Өөш, Долоодын говийн сав газарт тогтоосон газрын доорхи

усны экологи эдийн засгийн суурь үнэлгээгээр, 2013 оны 326, 327 тогтоолоор ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр, хувь хэмжээгээр усны нөөц ашигласны төлбөрийг тогтоож тогтоосон хэмжээгээр "Төсвийн тухай хууль"-ийн 23.8.9 дахь заалт, Өмнөговь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 06 сарын 12-ний өдрийн 51 дүгээр тогтоолын дагуу орон нутгийн төсөвт төвлөрүүлнэ.

1м³ усны нөөц ашигласны төлбөр 3996x15%x0,16=95.9 төг

- 3996 төг/м³- Галба-Өөш, долоодын говийн сав газарт газрын доорх усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ

0.16 – ашиг олох зориулалтаар унд, ахуйн ашигласан усны шоометр тутамд тооцох ашиглалтын зориулалтын итгэлцүүр

15%- ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуй нэгж байгууллага, иргэний ашигласан усны шоометр тутамд усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээ

<u>Унд ахуй:</u> **11,385 м³/жил * 96 төг = 1,092,960** *(нэг сая ерэн хоёр мянга есэн зуун жаран мянга төгрөг)*

<u>*Нийт төлбөр:*</u> **1,092,960** *(нэг сая ерэн хоёр мянга есэн зуун жаран мянга төгрөг)*

- *Усны нөөц ашигласны төлбөрийг Усны тухай хуулийн 30.1.4-т заасны дагуу эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан усны тоолуур суурилуулж тоолуурын заалтаар тооцон сар бүрийн 25-ний дотор сумын Байгаль хамгаалагчаар тоолуурын баталгаажуулалт хийлгэж төлбөрийг сар бүр орон нутгийн төсөвт төлж барагдуулах*
- *Сар бүрийн 25-нд татварын нэгдсэн сайтаар орж, төлбөрийн даалгавар үүсгэж, нэхэмжлэхний дугаараар төлнө.*

2.11 Хаягдал усан дахь нэгж бохирдуулах бодист ногдох төлбөрийн хэмжээ:

**Гурав. Талуудын эрх, үүрэг**

Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуулийн 7.5, 10.1.18, 13.1.1, 13.1.5, 18.1.4, 19.1.2, 19.1.4, 26.1, 30.1, 30.2, 31.1-д заасан дагуу эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

**Дөрөв. Бусад**

4.1 Гэрээ нь талуудын гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2 Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, хаягдал усны талаарх дүгнэлт, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.

4.3 Гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тэмдэглэл үйлдэнэ.

4.4 Талуудын тохиролцоноор / хууль, Засгийн газрын тогтоол, журамд өөрчлөлт орсон тохиолдолд / гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.

4.5 Гэрээг дор дурдсан үндэслэлээр хугацаанаас нь өмнө цуцалж болно.

4.5.1 ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн.

4.5.2 Аль нэг тал татан буугдсан бол.

4.6. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

**Ус ашиглуулагчийг төлөөлж:**

Ханбогд сумын ЗДТГ-ын Уул уурхай-Ус хариуцсан Байгаль хамгаалагч

О.Ангараг

Хаяг: Ханбогд сумын ЗДТГазар 103 тоот

Харилцах утас: 88545444

И-мэйл хаяг: angaa_zdtg@yahoo.com

**Ус ашиглагчийг төлөөлж:**

"Цагаан дэлгэрэх өргөө" ХХК-ийн Гүйцэтгэх захирал

Г.Мөнхзул

Хаяг: Хан-Уул дүүрэг 17-р хороо, Маршал таун, Кинг тауэр хотхоны 134-р байр 100/3 тоот оффис

Харилцах утас: 89081500 88105328

И-мэйл хаяг: ceo@tsdu.mn

БАТЛАВ:

"ЦАГААН ДЭЛГЭРЭХ ӨРГӨӨ" ХХК

/Г.МӨНХЗУЛ/

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

БАТЛАВ:

"УНДАЙН ХӨВӨӨ" ХХК

/Ц.ЭНХМАНДАХ/

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

**ТҮРЭЭСИЙН ГЭРЭЭ**

2022 оны 08 -р сарын 30-ны өдөр №  Улаанбаатар хот

Энэхүү **ТҮРЭЭСИЙН ГЭРЭЭ** (цаашид "Гэрээ" гэх)-г нэг талаас Ундайн хөвөө ХХК (цаашид "Түрээслүүлэгч" гэх) түүнийг төлөөлж гүйцэтгэх захирал Ц.Энхмандах, нөгөө талаас **Цагаан дэлгэрэх өргөө ХХК** (цаашид "Түрээслэгч" гэх) түүнийг төлөөлж гүйцэтгэх захирал Г.Мөнхзул нар (хамтад нь "Талууд" гэх) Монгол Улсын Иргэний хуулийн 318 дугаар зүйл болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журмыг удирдлага болгон дараах нөхцлийг харилцан тохиролцон байгуулав.

**1. Нийтлэг заалт**

1.1 Энэхүү гэрээгээр түрээслүүлэгч нь 32-23 ӨМЕ улсын бүртгэлийн дугаартай, LGAX4C441N1005269 арлын дугаартай, Dong Feng XZL5253-GSS3 маркийн цагаан өнгийн цистерн тээврийн хэрэгслийг /цаашид Хөрөнгө гэх/ түрээслэгчийн эзэмшил, ашиглалтанд шилжүүлэх, нөгөө талаас түрээслэгч нь түрээсийн төлбөрийг төлөх, талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулна.

1.2 Түрээслэгч нь тээврийн хэрэгслийг ус зөөвөрлөхөд ашиглана.

1.3 Явах газар нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын Цагаан хад суурьшлын бүс дотор.

1.4 Гэрээний 1.1-т тусгагдсан тээврийн хэрэгслийг жолоодох жолоочийг түрээслэгч хариуцна. Мөн засвар үйлчилгээний зардлыг түрээслэгч хариуцна.

1.5 Уг тээврийн хэрэгсэл нь бусдад худалдаагдаагүй, барьцаалагдаагүй, битүүмжлэгдээгүй, түрээслэгдээгүй болно.

**2. Гэрээний хугацаа**

2.1 Энэхүү Гэрээ нь 2022 оны 08 дугаар сарын 30-ний өдрөөс 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдрийг дуустал 1 жилийн хугацаатай байна.

2.2 Гэрээний хугацаа дуусахад талуудын эрх бүхий албан тушаалтан гэрээг дуусгавар болгон цуцлах талаар санал тавиагүй тохиолдолд энэхүү гэрээг анх байгуулсан хугацаагаар сунгагдсанд тооцно.

**3. Түрээсийн төлбөр**

3.1 Түрээсийн хөрөнгийн сарын төлбөр нь 7,500,000 /долоон сая таван зуун мянган/ төгрөг, усны төлбөр нь нэг литр нь 10 төгрөг байна. Гэрээний үнэд НӨАТ болон холбогдох бүх төрлийн татвар хураамж бүгд орсон болно.

3.2 Түрээсийн төлбөрийг дараа сард бэлэн бусаар төлнө. Дараа сарын 5-ны дотор төлбөрийн тооцоог хоёр талаас нийлж баталгаажуулсаны үндсэн дээр түрээслэгч талд нэхэмжлэлийг ирүүлэх бөгөөд

түрээслүүлэгчээс нэхэмжлэх ирсэн өдрөөс хойш ажлын 5 хоногийн дотор түрээслүүлэгчийн дансанд хийнэ.

## 4. Хөрөнгийг түрээсээр шилжүүлэн авах, буцаан өгөх журам

4.1 Түрээслүүлэгч нь түрээсийн гэрээ хүчин төгөлдөр болсон дараа түрээсийн хөрөнгийг түрээслэгчид иж бүрнээр нь хүлээлгэн өгсөн, хүлээн авсан тухай актаар баталгаажуулан хүлээлгэн өгнө. Тээврийн хэрэгслийн гэрчилгээний эх хувь болон усны шинжилгээний бичгийн хамт хүлээлгэн өгнө.

4.2 Түрээслэгч нь түрээсийн гэрээ дууссан өдөрт нь бүтээн түрээсийн хөрөнгийг түрээслүүлэгчид иж бүрнээр нь хүлээлгэн өгсөн, хүлээн авсан тухай актаар баталгаажуулан хүлээлгэн өгнө. Тээврийн хэрэгслийн гэрчилгээний хамт хүлээлгэн өгнө.

## 5. Түрээслүүлэгчийн эрх, үүрэг

5.1.1 Түрээслүүлэгч нь ашиглалтын шаардлага хангасан, биет байдлын болон эрхийн зөрчилгүй хөрөнгийг Түрээслэгчийн эзэмшил ашиглалтанд шилжүүлэх үүрэгтэй.

5.1.2 Түрээсийн хөрөнгийг шаардлагатай үед бэлэн байлгах үүрэгтэй.

5.1.3 Түрээслүүлэгч нь гэрээний 1.1-т тусгагдсан хөрөнгийг даатгалд хамруулсан байна.

5.1.4 Усанд холбогдох байгууллагын шинжилгээний бичгийг гаргуулсан байна.

5.1.5 Түрээслүүлэгч нь хөрөнгийн түрээсийн төлбөрийг Түрээслэгчээс шаардах эрхтэй.

5.1.6 Түрээслэгч Гэрээнд заасан үүргээ биелүүлээгүйгээс өөрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шаардах эрхтэй.

5.1.7 Ковид-19-тэй холбоотой Түрээслэгч болон орон нутгийн засаг захиргаа, шуурхай штабаас гарсан дүрэм журам, заавар, шаардлагуудыг чанд мөрдөж, Цагаан дэлгэрэх өргөө ХХК-ийн Өмнөговь аймгийн Ханбогд сумын Цагаан хад суурьшлын бүсийн Номгон багт байрлах ажилчдын хотхонд ковид-19-ын халдвар гаргахгүй байх үүднээс ажилчдын хотхон дохь ажилтан болон үйлчлүүлж буй зочидтой ойрын хавьтал үүсгэхгүй, зай барин ажиллах, захиалагч талын кемпийн дотоод журмыг чанд мөрдөж ажиллана.

5.1.8 Өөрийн ажилтнуудын Цагаанхад суурьшлын бүсэд нэвтрэхэд шаардлагатай ковид 19-ийг илрүүлэх шинжилгээ, шуурхай штабаас авах зөвшөөрлийг цаг тухай бүрт хариуцан авах үүрэгтэй.

## 6. Түрээслэгчийн эрх, үүрэг

6.1.1 Хөрөнгийг гэрээнд заасан нөхцөл болон зориулалтын дагуу ашиглах үүрэгтэй.

6.1.2 Гэрээнд заасан хугацаанд түрээсийн төлбөрийг төлөх үүрэгтэй.

6.1.3 Гэрээ дуусгавар болоход хөрөнгийн хэвийн элэгдэл хорогдлыг тооцон, бүрэн бүтэн байдлаар буцаан хүлээлгэн өгөх үүрэгтэй.

6.1.4 Энэхүү гэрээтэй холбоотой аливаа зардлыг түрээслэгч хариуцах мөн хөрөнгийн ашиглалтын бүхийл зардлыг хариуцах үүрэгтэй.

6.1.5 Түрээслэгч Түрээслүүлэгчийн зөвшөөрөлгүй хөрөнгийг бусдад давхар түрээслэх, худалдаалахыг хориглоно.

## 7. Талуудын хүлээх хариуцлага.

7.1 Талууд энэхүү гэрээнд заасан үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд Гэрээний үнийн дүнгийн 0,1 хувьтай тэнцэх алданги төлнө.

7.2 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс учирсан хохирлыг гэм буруутай тал нь нөгөө талд төлөх үүрэгтэй.

7.3 Хэрэв талуудын хооронд маргаан гарвал талууд эвийн журмаар шийдвэрлэх ба маргаанаа шийдвэрлэж чадахгүйд хүрвэл шүүхийн журмаар шийдвэрлүүлнэ.

## 8. Гэрээ цуцлах

8.1 Гэрээний аль нэг тал Гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд Гэрээг нэг талын санаачлагаар цуцлана.

8.2 Гэрээг цуцалсан тохиолдолд гэм буруутай тал бусдад учирсан хохирол болон нөгөө талд учирсан хохирлыг өөрийн зардлаар арилгана.

8.3 Талууд Гэрээг цуцалсан тохиолдолд Түрээслэгч хөрөнгийг бүрэн бүтэн, эвдрэл, гэмтэлгүй Түрээслүүлэгчийн өмчлөлд 7 хоногийн дотор шилжүүлэх өгнө.

## 9. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл

9.1 Энэхүү гэрээний зорилгын хүрээнд аль нэг талын боломжит хяналтаас гадуур гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал / байгалийн гамшиг, ган, зуд, үер, газар хөдлөлт, үйлдвэрлэлийн осол, замын түгжрэл, өвчин, зам тээврийн осол, дайн, төр засгийн эрх бүхий этгээдийн шийдвэрээр хорио цээр тогтоох/-ын улмаас энэ гэрээний дагуу хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх боломжгүйд хүрэх нөхцөл байдал үүссэнийг гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл гэж ойлгоно.

9.2 Гэнэтийн болон давагдашгүй нөхцөл байдлын улмаас гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлж чадаагүй талыг дээрх тохиолдолд энэ гэрээг зөрчсөн гэж үзэхгүй.

9.3 Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл байдлын улмаас гэрээний үүргээ биелүүлэх боломжгүй болсон буюу түүнд өртсөн тал нь энэхүү нөхцөл үүссэн тухай нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ.

## 10. Бусад

10.1 Талууд энэхүү Гэрээнд гарын үсэг зурсанаар хүчин төгөлдөр болно.

10.2 Талууд Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

10.3 Гэрээний нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж Талуудын гарын үсэг зурсанаар хүчин төгөлдөр болно.

## ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

| Түрээслэгч төлөөлж: | Түрээслүүлэгч төлөөлж: |
|---|---|
| ______________ | ______________ |
| Цагаан дэлгэрэх өргөө ХХК-ийн | Үндэсний хөвөө ХХК-ийн |
| Ахлах нягтлан бодогч | ........................................ |
| М.Мөнхцэцэг | ........................................ |
| Утас: 7771-1110, 8900-3105 | Утас: 88093866 |

УБ-2

Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 20 дугаар тогтоолоор батлав

# МОНГОЛ УЛС
# УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

2013.12.16 / Бүртгэсэн он, сар, өдөр /

№ 000045271

1111008057 / Улсын бүртгэлийн дугаар /

5523815 / Регистрийн дугаар /

Үндэсний ... Хязгаарлагдмал хариуцлагатай компани

/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм

/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

| | | |
|---|---|---|
| Шийдвэр | 1/1 | 2013.12.13 |
| / шийдвэрийн нэр / | / дугаар / | / он, сар, өдөр / |

| | |
|---|---|
| 7410 | Барилгын ... засал |
| / код / | / Хийсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл / |
| 4923 | Хуурай замаар нийтийн ачаа тээвэр |
| 1610 | Гадаад худалдаа |
| 7730 | Ажлын байр түрээслэх |

/ код / ... / ... эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

| | | |
|---|---|---|
| Хугацаагүй | 1 | 1,000.00 |
| / хугацаа / | / эзэмшигчийн тоо / | / эзэмшигчийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр / |

Өмнөговь, Ханбогд, 2-р баг, Жавхлант, ... 18, 26, Утас1 99..., Утас2 88..., Ф.э.с

/ хуулийн этгээдийн хаяг, холбоо барих хаяг /

